



ХӨГЖИЛД
ХАМТДАА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

2024.04.29

ХУРАЛД ОРОЛЦОХ ЗААВАРЧИЛГАА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн оноосон нэр, хаяг:

Худалдаа, хөгжлийн банк ХК

Монгол Улс, Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байр

Хуралд оролцох хэлбэр:

Хосолсон /танхим болон зайнаас/

Хурал хуралдах өдөр, цаг:

2024 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 09 цаг 00 минутад

Хурал хуралдах газар:

Танхим: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байрны 1 дүгээр давхарт
Зайнаас: investor.tdbm.mn цахим хаягаар.


Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдөр:

2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр

ХУРЛЫН МАТЕРИАЛ БОЛОН ХОЛБОГДОХ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАХ ЖУРАМ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид дараах арга, хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай **2024 оны 4 дүгээр сарын 17-ны** өдрөөс эхлэн танилцаж болно. Үүнд:

- ✓ Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хаягт хандан, хурлын материал хэсгээр дамжуулан танилцах;
- ✓ Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан танилцах;
- ✓ 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд Худалдаа, хөгжлийн банкны төв байранд ажлын өдрүүдийн 10:00-17:00 цагийн хооронд ирж, Хурал зохион байгуулах комисст мэдэгдэн танилцах боломжтой.



ХУРАЛД ОРОЛЦОХ, САНАЛ ӨГӨХ ЗААВАР

Хувьцаа эзэмшигч Та дараах аргуудын аль нэгээр хуралдаа оролцож санал өгөх боломжтой. Үүнд:

- **Урьдчилсан санал өгөх**
- **Танхимаар оролцох**
- **Зайнаас оролцох**

Урьдчилсан санал өгөх:

Цаасан хэлбэрээр санал өгөх:

- Саналын хуудсыг 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл Худалдаа, хөгжлийн банкны төв байранд Тооллогын комисс хүлээн авна.

Цахим хэлбэрээр санал өгөх:

- Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хуудсанд хандан 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл саналаа өгөх боломжтой.

Та саналын хуудсыг бөглөхдөө “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас” дахь зааварчилгаатай сайтар танилцана уу.

Танхимаар оролцох:

Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигчид хурлын өдөр буюу **2024 оны 4 дүгээр сарын 29-ний** өдрийн **08:30 цагаас эхлэн 08:50 цаг хүртэл** бүртгэлээ хийлгэж, танхимд нэвтэрсэн байна.


Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигч нь:

- **Хувь хүн бол:** Хүчин төгөлдөр иргэний үнэмлэх эсхүл гадаад паспортыг шалгуулан танхимд нэвтэрнэ. Итгэмжлэгдсэн төлөөлөгч бол нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэлийн хамт хүчин төгөлдөр иргэний үнэмлэх эсхүл гадаад паспортыг шалгуулан нэвтэрнэ.
- **Хуулийн этгээд бол:** Хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцож буй этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хувьцаа эзэмшигчийн хуралд төлөөлөн оролцох эрх бүхий этгээдийг томилсон шийдвэр (Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол гэх мэт)-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Тооллогын комисст хүлээлгэн өгч, өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэх эсхүл гадаад паспортыг шалгуулан танхимд нэвтэрнэ.


<https://investor.tdbm.mn/> цахим хаягт хандан хурлын мэдээ, мэдээлэлтэй танилцах боломжтой. Хувьцаа эзэмшигчдийн хуралд цахимаар оролцох тохиолдолд **“Хуралд оролцох”** товчийг даран орно.

Хурлын программд нэвтэрч орсноор:

- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлын шууд дамжуулалтыг үзэх
- ✓ Цахимаар урьдчилсан санал өгөх
- ✓ Хуралд цахимаар оролцох хувьцаа эзэмшигчид 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цагаас өмнө программд нэвтэрсэн байна.



Хувьцаа эзэмшигч нь иргэн бол **ХУВЬ ХҮН** сонголтыг сонгон Регистрийн дугаараа оруулан “**ДАН нэвтрэх**” товчийг дарна.



The screenshot shows the 'DAN Nэвтрэх' (DAN Login) page on the TDB Investor Portal. The page has a dark blue header with navigation links: 'Хурлын зар', 'Хурлын дэг', 'Мэдээ, мэдээлэл', 'Асуулт, хариулт', and a language selector 'EN'. The main content area is white with a blue border. It features the TDB logo and a 'Холбоо барих' (Contact Us) link. The 'DAN Nэвтрэх' section includes a progress indicator with three steps: '1. DAN Нэвтрэх', '2. Хувийн мэдээлэл оруулах', and '3. Хүснэгт нэгээх'. Below this, there are two buttons: 'Хувь хүн' (Individual) and 'Байгууллага' (Organization). A registration number field is labeled '* Регистрийн дугаар:' and contains the characters 'А А'. A large blue button labeled 'ДАН Нэвтрэх' is positioned below the registration number field. A sidebar on the right contains the TDB logo and contact information: 'Хэзээ: 2024.04.29 09:00', 'Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байрны 1 дүгээр давхар www.investor.tdbm.mn'.

❖ **Хуулийн этгээдийг төлөөлөн хуралд цахимаар оролцох** тохиолдолд хуулийн этгээдийн *улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар*, хувьцаа эзэмшигчийн хуралд төлөөлөн оролцох эрх бүхий этгээдийг *томилсон шийдвэр* (Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол гэх мэт)-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Тооллогын комисст **урьдчилан хүлээлгэн өгсөнөөр** хуралд цахимаар оролцох боломжтой болно.



❖ Урьдчилан цахимаар санал өгөх хувьцаа эзэмшигчид 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл саналаа өгөх боломжтой.

* 2024 оны 4 сарын 9-ний өдөр буюу бүртгэлийн өдрөөр ХХБ-ны Хувьцаа эзэмшигч биш бол нэвтрэх боломжгүй болохыг анхаарна уу.

ХУВЬ ХҮН БОЛОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

Танилт нэвтрэлтийн систем болох **“ДАН систем”**-рүү та банкны эрхээр болон доорх зурагт үзүүлсэнчлэн өөрийн боломжит хувилбарыг сонгон орно.


Танилт нэвтрэлтийн систем нь таны **“Иргэний үнэмлэхний мэдээллээр”** баталгаажуулалт хийгдэх тул доорх дэлгэц дуудагдаж та **“ЗӨВШӨӨРӨХ”** товч дарсанаар баталгаажуулалтын хэсэг амжилттай хийгдэнэ.



Хурлын программд нэвтэрч орсноор

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын шууд дамжуулалтыг үзэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах;
- Хэлэлцэж буй асуудалтай холбоотой санал өгөх заавартай танилцах;
- Хэлэлцэж буй асуудалтай холбоотой санал өгөх;
- Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт асуух, хариулт авах боломжтой болно.

Шууд дамжуулалт




Асуулт асуух

Санал асуулга

Унших

Хэвлэх

 Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 2 тоот тогтоолын Хаварлалт 3-аар "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас"-ын агуулгыг зарварыг батлав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Компанийн оноосон нэр: "Худалдаа, хөгжлийн банк" ХК

Саналын хуудас, зааварчилгааг уншиж танилцсан

Хэлэлцэх асуудал 1: Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувь нийлүүлсэн:

Зөвшөөрсөн
 Татгалзсан
 Түдгэлзсэн

Хэлэлцэх асуудал 1: Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай111:

Зөвшөөрсөн
 Татгалзсан
 Түдгэлзсэн

Санал өгөх

⚠ Алдаатай мэдээлэл байвал ажилтанд хандаж засуулна уу!

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахимаар санал авах хуудас

Санал хураах арга: Ердийн

Саналын хуудас, зааварчилгааг уншиж танилцсан.

| | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|-----------------------|-----------------------|-----------------------|
| Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай | <input type="radio"/> | <input type="radio"/> | <input type="radio"/> |
| Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай. | <input type="radio"/> | <input type="radio"/> | <input type="radio"/> |

Хурал зохион байгуулах комисстой холбоо барих мэдээлэл:

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 14210,
Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банкны төв байр
Утас: 11 328227

Цахим хаяг: boardoffice@tdbm.mn

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.



Хөгжилд хамтдаа